

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2011-03-20

**1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ**

**1.1 Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын талаар**

Мянганы хөгжлийн зорилтод /МХЗ/ суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын /ҮХЦБ/ тайланг боловсруулахдаа орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг түүвэрлэн авах замаар хийсэн бөгөөд эдгээр зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийж үзээд хэрэгжилт 29.4 хувьтай байна гэж үзлээ. /khentii2010Re2.doc/

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ХШҮ-ний тасаг нь холбогдох бодлого хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын эхний шатны үнэлгээг 2006 оноос (МХЗ-д суурилсан ҮХЦБ-ын суурь он) 2010 оныг дуусталх хугацааг хамруулан, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалаар хийж гүйцэтгэхийг хичээлээ. Үнэлгээ нь мэдээлэл цуглуулах анхдагч хүснэгтээр ирүүлсэн мэдээлэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, холбогдох агентлаг, газар, хэлтсүүдийн жилийн эцсийн тайланд үндэслэсэн бөгөөд холбогдох байгууллагын зарим мэргэжилтнүүдтэй биечлэн уулзаж, үндсэн мэдээллийг баталгаажуулсан.

**1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар**

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс аймаг орон нутагт холбогдолтой нийт 154 зорилтот арга хэмжээний биелэлтийг Засгийн газарт жил бүр тайлагнан ажиллаж байна. Энэхүү зорилтуудын хэрэгжилтийг 2008-2012 онд харьцуулсан байдлаар Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийж үзэхэд 57.8 хувийн биелэлттэй байна. /Khentii2010Re3.doc/

Эрүүл мэндийн чиглэлээр Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажилласнаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, төлбөрийн чадваргүй, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгийн тусламж хүргэх, алсын зайн оношлогоо хийх, халдварт өвчинтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажлууд нь зохих үр дүнгээ өгч байна. Эрүүл мэндийг дэмжигч 44 байгууллагыг тодруулан урамшуулсан, явуулын амбулаториор 14000 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн, аймгийн төвийн болон сумдын эмнэлэгийн байгууллагуудын техникийн парк шинэчлэлтийг эрчимтэй сайн хийсэн /1.1.7.5/, сумдын эмнэлэгүүдийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад анхаарч ажилласнаар өрх, сумын их эмчийн хангалт 100 хувьд хүрсэн байна. Хөдөөгийн 54 багийн 39 нь буюу 70,3 хувь нь эмчээр хангагдсан байна. 2010 онд эхийн эндэгдэл гараагүй байна.

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, спортоор хичээллэхийн ач тусыг иргэдэд сурталчлан таниулах талаар тодорхой ажлууд зохион байгуулж үр дүнд хүрсэн байна. Спортын арга хэмжээнд 2010 онд орон нутгийн төсвөөс 13,8 сая төгрөг зарцуулж, хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэхэд анхаарч хүүхдийн тоглоомын талбай, соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулах, сургуулиудын спорт заал засварлах ажилд нийт 95,1 сая төгрөг зарцуулсан байна.

2010 онд зуны улиралд гэр цэцэрлэгт хүүхдүүдийг хамруулах ажил сайжирлаа. 2009 онд 26 багт 26 гэр цэцэрлэг ажиллаж байсан бол 2010 онд 50 багт 62 гэр цэцэрлэг ажиллаж хамрагдалт 89,2 хувьд хүрч, өмнөх оноос 10,7 хувиар ахисан байна. Бага боловсролын хамран сургалтыг 95 хувьд хүргэнэ гэсэн Засгийн газрын зорилт бүрэн биелэгдэж, 2009- 2010 онд хамран сургалт 97,5 хувьд хүрсэн байна.

Үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэх журам гараагүй байгаа боловч аймгийн хэмжээнд бүх сургууль 7 хоногийн 3-аас дээш өдөрт халуун хоолоор тогтмол үйлчилж хэвшээд байна.

2010 онд 1217 иргэн ажлын байранд зуучлагдаж, ХЭДСангаас 375 иргэнд 342,0 сая төгрөгийн бичил зээл олгож, малгүй болсон буюу малаа их хэмжээгээр хорогдуулсан малчин өрхүүдэд ХЯБХ-өөс 80,0 сая төгрөгийн 1603 бог мал олгосон байна. /1.3.6.2/

Аймгийн МСҮТ-өөр дамжуулан ажилгүй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг эрчимтэй зохион байгуулснаар сургалтанд хамрагдсан иргэдийн 73,0 хувь буюу 215 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдсан байна.

“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” баталж гаргах, “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлах зэрэг ажлууд нь нийгмийн хамгаалал, хүн амын бодлогын чиглэлийн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж батлуулаагүйгээс шалтгаалан хэрэгжээгүй байна.

Хэнтий аймаг улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг сүүлийн 3-н жил дараалан давуулан биелүүлж, энэ хэмжээгээр орон нутгийн бүтээн байгуулалтанд зарцуулагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. Мөн орон нутгийн төсөвт 5567,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орон нутгийн зарлагаас давсан 358,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2009, 2010 оны гүйцэтгэлээр **орлогын өсөлт зарлагын өсөлтөөс түрүүлж**, төсвийн урсгал болон нийт тэнцэл сайжирсан байна.

Аймаг өөрийн онцлогт тохируулж “Хэнтий аймгийн хөгжлийн цогц хөтөлбөр” /2010-2021 он/-ийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2010 оны 25 дугаар тогтоолоор хөнгөлөлттэй зээл олгох 13 чиглэлийг батлуулж аймгийн “Жижиг, үйлдвэрийг дэмжих дэд сан”-гийн 816,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг энэхүү чиглэлийн дагуу олгосон нь аймгийн хөгжлийн чиг хандлагатай уялдсан байна. “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн, “Сүү”, “Чацаргана” “Ногоон хувьсгал”, “Атрын 3 дахь аян”, “Малын тэжээл”, “Мал эмнэлэг, үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр”, “Хоршоог дэмжих хөтөлбөр”, “Мал сүргийг зарим зооноз халдварт өвчнөөс эрүүлжүүлэх хөтөлбөр” зэрэг үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүд нь 50-70 хувь хэрэгжиж байна. Ялангуяа “Малын тэжээл” хөтөлбөр амжилттай сайн хэрэгжиж байна. 2010 онд төлөвлөгөөт өвсийг 102.2%, ногоон тэжээлийг 9 дахин, үйлдвэрийн тэжээлийг 101.8%, гар тэжээлийг 131.9% давуулан биелүүлсний зэрэгцээ аймгийн төв болон Хурх тосгонд тэжээлийн үйлдвэр тус тус шинээр байгуулан тэжээл үйлдвэрлэж эхлээд байна.

Хэрлэн суманд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж ландфиллын аргаар дарж булах ажил 2010 оноос хийгдэж эхэлсэн бөгөөд уг ажлын хүрээнд хоногт 500 кг хуванцар гялгар уут боловсруулах бага оврын үйлдвэр байгуулж тоног төхөөрөмжийг угсраад байна.

Гол мөрний сав газруудын зөвлөлийг байгуулах, гар худгуудыг сэргээн засварлах, шинээр гаргах, хөв цөөрөм байгуулах, ойжуулах, мод, бут, сөөг тариалах, бэлчээр хаших, ашиглах менежментийг нь сайжруулах чиглэлээр /3.3-3.14/ тодорхой ажлуудыг амжилттай зохион байгуулсан байна.

Харин хотын цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэл хийх, хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулах ажлууд хөрөнгө санхүүгийн асуудлаас шалтгаалан удаашралтай хэрэгжиж байна.

### **1.3 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар**

Хэнтий аймгийн хэмжээнд байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, соёл, боловсрол, дэд бүтэц, нийгэм, амьтан ургамал зэрэг 11 салбарыг хамарсан нийт 80 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээрээс 2010 онд хэрэгжүүлэх хугацаа нь дуусаж буй 24 хөтөлбөр байна. Хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг салбараар нь авч үзвэл барилга, санхүү, амьтан ургамал, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд хамгийн сайн буюу 90-100 хувь хэрэгжиж дууссан болон хэрэгжиж байна. Харин аж үйлдвэр, байгаль орчин, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд 68,0-87,0 хувийн хэрэгжилттэй байна.

“Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр”, “Монгол орны идлэг шонхрыг хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Сумдын төвийн цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах хөтөлбөр”, “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүд бусад хөтөлбөрүүдээсээ илүү үр дүнтэй хэрэгжиж дууссан байна.

“Арьс шир дэд хөтөлбөр” нь тус аймагт анхан шатны боловсруулах үйлдвэр байхгүйгээс шалтгаалан үр дүнтэй хэрэгжиж чадаагүй байна.

Харин 2010 оноос хэрэгжиж эхэлж байгаа “Чацаргана”, “Монгол мал хөтөлбөр” зэрэг нь эрчимтэй сайн хэрэгжих төлөвтэй байна.

Орон нутагт нийтлэг ажиглагдаж байгаа нэг асуудал бол тухайн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгө төсөвлөгдөж ирдэггүй /Эрүүл мэндийн салбараас бусад/, орон нутгаас санхүүжүүлэх боломж муутай, зарим төсөл, хөтөлбөрүүдэд зориулан зарцуулсан хөрөнгийн хэмжээ тодорхой биш зэрэг шалтгаанаар биелэлтийг тооцоход хүндрэлтэй зүйл тулгарч байна. Мөн зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд заавал хөрөнгө мөнгө шаардлагагүй, зөвхөн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрүүдийн хувьд хэрэгжүүлсэн ажлыг үнэлж мөнгөн дүнгээр илэрхийлэн тавих боломжгүй байлаа.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2010 оны 11, 285 дугаар тогтоолд заасны дагуу хяналт шинжилгээ хийж үзэхэд 87,2 хувь буюу 4,36 оноотой байна. /Khentii2010Re4.doc/

## **2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ**

### **2.1 Монгол улсын эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн талаар**

Монгол улсын эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн аймаг орон нутагт хэрэгжүүлэх нийт 54 зорилтот арга хэмжээнд Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийхэд биелэлтийн дундаж хувь 94,1 хувь буюу 4.6 оноотой байна. /Khentii2010Re5.doc/

Аймгийн Засаг даргын 2010 оны 56 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, 2010 онд ЖДҮ-ийн хүрээнд хэрэгжүүлэх 13 чиглэлийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулан нийт 816 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон нь аймгийн хэмжээнд ажлын байр шинээр бий болох, ЖДҮ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээнд тодорхой ахиц гарахад нөлөөлсөн байна. Мөн сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн цогцолбор аж ахуй бий болгох, махны чиглэлийн үхэр, хонины цогцолбор аж ахуйг шинээр байгуулахад нь зориулж 21 иргэн, аж ахуйн нэгжид 5,0-40,0 сая төгрөгийн зээл тус тус олгосон байна. "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2", "Сүү" үндэсний хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Гол мөрний бохирдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж, булаг шанд, гол горхины эхийг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, бүх нийтээр мод тарих зэрэг ажлуудыг сайн зохион байгуулсан байна.

Хүний хөгжил сангаас олгож байгаа иргэн бүрт хишиг хувь хүртээх ажлын явц 94,3 хувьтай явагдаж байгаагийн зэрэгцээ 2010 онд малгүй болсон буюу малаа их хэмжээгээр хорогдуулсан малчин 20 өрхөд Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслөөс 80 сая төгрөгийн 1603 толгой бог мал олгосон байна.

## **2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдлын талаар**

Тайлант хугацаанд Монгол улсын Ерөнхийлөгчийн Зарлиг 1, Засгийн газрын тогтоол 40, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 7, Ерөнхий сайдын захирамж 1-ийг шинээр бүртгэн, Ерөнхийлөгчийн Зарлигийн 1 заалт, Засгийн газрын тогтоолын 53 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 7 заалтыг тус тус нэмж хяналтанд авсан байна.

Биелэлтийг тооцохдоо 2005-2009 онуудад гарсан зарим шийдвэрүүдийн заалтууд нь бүрэн хэрэгжсэн буюу хэвшсэн гэж үзээд Засгийн газрын 33 тогтоолын 61 заалт, 9 хуралдааны тэмдэглэлийн 12 заалт, Ерөнхий сайдын 6 захирамжийн 7 заалт, 1 албан даалгаварын 5 заалтыг хяналтаас хассаныг шийдвэрүүдийн нэр, заалтаар гаргаж хавсаргав.

2010 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг хяналтанд байгаа нийт 147 шийдвэрийн 236 заалтын биелэлтийн явцад хяналт шинжилгээ хийж үзэхэд тогтоол, шийдвэрийн хэрэгжилт нийт дүнгээрээ 94,8 хувийн биелэлттэй байна. /Khentii2010Re6.doc/

## **2.3 Аймгийн Засаг даргаас Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламж гэрээний талаар**

Аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар нь Монгол улсын Ерөнхий сайдтай 10 зүйл заалт бүхий батламж гэрээ байгуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Эдгээр заалтуудын хэрэгжилтийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийж үзэхэд 100 хувь хэрэгжсэн 6 заалт, 90 хувийн хэрэгжилттэй 4 заалт байна.

Монгол улсын Ерөнхий сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан батламж гэрээний биелэлт нийт дүнгээрээ 96 хувь буюу 4.8 оноотой байгаа нь Ерөнхий сайдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үнэлэхээр байна. /Khentii2010Re7.doc/

Аймгийн эдийн засаг нийгмийн үзүүлэлтүүд сайжирч, 2009-2010 онд төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс давсан, Монгол улсад хамгийн анх удаа "Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн дээдлэгч аймаг" болох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа, орон нутагт шаардлагатай мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх зорилгоор "Сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулах журам" боловсруулан мөрдөж, 2009-2010 онд 11 хүүхдэд 7,4 сая төгрөг зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, бүсийн зөвлөгөөнүүд зохион байгуулж, мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийн талаар жил бүр аймгийн ИТХ-д танилцуулж, "Хангалттай сайн хэрэгжсэн" гэсэн үнэлэлт дүгнэлттэй ажилласан байна.

## **2.4 Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар**

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр нь 6 үндсэн зорилт, 111 заалт, 245 хэрэгжүүлэх арга хэмжээнээс бүрдэж байна. Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилт 48.8 хувь, Боловсрол, соёл урлаг, спортын талаар хэрэгжүүлэх зорилт 62.4 хувь, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн салбарын чиглэлээр хэрэгжүүлэх зорилт 57,8 хувь, төрийн байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх зорилт 60,0 хувь, Дэд бүтэц, үйлдвэрлэлийг хөгжүүлэх эдийн засгийн өсөлтийг хангах зорилт 62,4 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны хөгжлийг хангах зорилт 64,1 хувийн биелэлттэй, нийт дундаж хувь нь 59,7 хувь буюу 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай харьцуулан дүгнэвэл 5,0 оноотой байна. /Khentii2010Re8.doc/ 2010 оны онцлох 10 ажлыг дурьдвал:

1. Иргэдэд хууль тогтоомж сурталчлах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) , [www.khentii.mn](http://www.khentii.mn) зэрэг цахим орчноос мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр бүх сумдын ЗДТГ-ыг Жи-Мобайлын интернет модемоор хангалаа. Ингэснээр бүх сумд аймгийн ЗДТГ болон албан байгууллагуудтай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох бүрэн боломжтой болж, амьдралд хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Хууль тогтоомжийн бичмэл сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх сум, хот тосгоны ЗДТГ, захирагчийн ажлын албыг “Хуулийн эмхэтгэл” 4 ботиор хангаж уг ажилд орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөг зарцууллаа.
3. **"Иргэний нийгмийн байгууллагуудын чуулган"**-ыг зохион байгуулж Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах **"Санамж"** бичигт гарын үсэг зурлаа. Чуулганы арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөцөөс 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Энэ үеэр аймгийн ЗДТГ, Иргэний Нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх чиглэлийг тодорхойллоо.
4. Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар “Хэнтий аймгийн Шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардалд 8.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулав. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 2009 онд Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд санал асуулгад оролцсон иргэдийн 36,9% нь сэтгэл ханамжтай байгаагаар илэрхийлж байсан бол 2010 онд 39.7% нь сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж , ил тод, нээлттэй байдал дээшилж байгааг харуулж байна.
5. 2010 оныг "Багийн хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж, энэ ажлын хүрээнд бүх сумын төвийн болон хөдөөгийн 76 багийн Засаг даргыг мотоциклоор /67,3 сая төг/ хангаснаар нийт багийн Засаг дарга нарын 95.6 хувь нь иргэддээ хүрч ажиллах бүрэн боломжтой боллоо. Энэ онд 9 багийн төвийг шинээр барихад 153,0 сая төгрөг, нийт багийн төвүүдийн тохижилтонд зориулж 140,0 сая төгрөг , малын хулгайтай тэмцэх ажлын хүрээнд багийн Засаг дарга нарыг 100 хувь фотоаппаратаар хангахад 17,4 сая төгрөг буюу нийтдээ 377,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг багийн хөгжилд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжүүлээ.
6. БСШУЯ-наас дэвшүүлэн тавьсан “Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах” зорилт, Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх зорилгоор "Сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулах журам" батлагдаж, барилгын инженер, архитектор, авто зам, авто тээврийн инженер, компьютер программ хангамж, агрономич, дулаан, цахилгаан, холбооны инженер, нийтийн хоолны технологич, хүнсний технологич, мах, сүү боловсруулах үйлдвэрийн технологи, эм зүйч, малын эмч, хөгжим, бүжгийн багш, ойн инженер мэргэжлээр суралцах оюутнуудтай орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээ байгуулан сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан санхүүжүүлж байна. 2009, 2010 онуудад журмын шаардлага хангасан 7 оюутны сургалтын төлбөрт нийт 4,7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулаад байна.
7. Эрүүл мэндийн салбарын 85 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд ЭМШУИС-тай хамтран багш шавийн эрдмийн уулзалт, онол практикийн эрдэм шинжилгээний бага хурал хийж, энэ үеэр зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал ба цаашдын зорилт” сургалт зөвлөгөөнд Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, дэд сайд Ж.Цолмон нар оролцов. Тус зөвлөгөөний үеэр Эрүүл мэндийн яам болон аймгийн удирдлагууд "Хэнтий аймгийн Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны стратеги"-д гарын үсэг зурж баталгаажууллаа. Зөвлөгөөн сургалтанд нийт 120 гаруй төлөөлөгчид оролцсон байна.
8. Аймгийн Засаг даргын захирамжаар “Явуулын амбулатори” ажиллуулж, сумдыг 3 бүс болгон нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг зохион байгуулснаар нийт 17 сумын 14090 иргэн хамрагдаж, 2.4 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа.

9. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Ажил олгогч эзэд болон Үйлдвэрчний эвлэлийн холбоодын аймгийн хэмжээний байгууллагууд “Хөдөлмөрийн тухай хууль”, “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль” зэргийг үндэслэн аймгийн хэмжээнд мөрдөх хүн амын нийгмийн хамгааллын болон иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд үүссэн “Хөдөлмөрийн харилцааны асуудлаар ”Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-ийг байгуулсан.
10. 2010 онд Хэрлэн сумын 3-р багт орон нутгийн төсвийн 51,0 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхэд, залуучуудад зориулсан “Соёл амралтын хүрээлэн” байгуулж, 3,4 га газрыг хашаажуулан усан оргилуур байгуулж, сагсан бөмбөгийн талбай болон зарим тоглоомуудыг суурилуулж тохижуулах ажил хийсний зэрэгцээ 300 гаруй мод суулгаад байна.

### **3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ**

#### **3.1 Сайдуудтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн талаар**

2010 онд Хэнтий аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар 8 яамны сайдуудтай давхардсан тоогоор 408 заалт бүхий гэрээ байгуулан ажиллаж, нийт дүнгээрээ 90,5 хувиар биелүүлсэн байна. /Khentii2010Re9.doc/

ХЗДХЯ, БОАЖЯ, БХЯ, НХХЯ, ХХААХҮЯ, ЭМЯ-ын сайдуудтай байгуулсан гэрээний биелэлт 90-100 хувийн биелэлттэй гарсан бол, ЗТБХБЯ, БСШУЯ,-ын сайдуудтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 80-81,3 хувьтай гарсан нь тоосгоны үйлдвэр, цементийн үйлдвэр шинээр байгуулах, газар хөдлөлийн гамшгаас хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлууд бүрэн хийгдээгүй, сургуулийн өмнөх боловсрол тэр дундаа цэцэрлэгийн хамран сургалт, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь, бүлэг дүүргэлт, дотуур байрны хамрагдалт товлосон зорилтдоо хүрээгүй зэрэг шалтгаантай холбоотой байна.

#### **3.2 Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлт**

Тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийлүүлбэл зохих нийт бүтээгдэхүүний тоо 221, нийлүүлбэл зохих тусгай захиалгат бүтээгдэхүүний тоо 58, нийт гэрээний үүргийн биелэлт 93,3 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна. Үр дүнгийн гэрээнд Засгийн газраас давшүүлэн тавьсан зорилтууд болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд бүрэн хамрагдаж, тэдгээр баримт бичгүүдтэй нягт уялдуулан боловсруулсан байна. Гэрээний заалт тус бүрийг холбогдох хэлтэс, агентлагийн ажлын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх талаар хяналт тавьж ажилласан нь үр дүнд хүрч, ЗДТГ-ын бодлогын мэргэжилтнүүдийн ажлын дүн, үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт өнгөрсөн жилээс 3,8-8,8 пунктээр ахисан үзүүлэлттэй гарсан байна. Khentii2010Re10.doc/

### **4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ**

Иргэдэд ажил үйлчилгээгээ нээлттэй ил тод хүргэх үүднээс байгууллагын цахим хаяг, вэб хуудасыг Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим сүлжээнд <http://www.Khentii.gov.mn> хаягаар байршуулж, иргэдээс санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авах, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, төрөл бүрийн мэдээллийг тавьж байршуулан тогтмол баяжилт хийж байна.

Байгууллагын ил тод, шударга, иргэдэд нээлттэй байдлыг хангах зорилгоор НҮБ-ын ХХГ, АТГ-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад шударга ёс ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн багтай хамтран ажиллаж Авилгын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-тэй уялдуулан боловсруулсан байна. Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны хүнд суртал, иргэдийг чирэгдүүлдэг, хариуцлагагүй, ёс зүйгүй байдлыг арилгах зорилгоор аймгийн Засаг даргын санал болгосноор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллага иргэдийн санал авах ажлыг нээлттэй зохион байгуулан, мөн Авлигатай тэмцэх газрын санал зөвлөгөөг тусгаж “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгуудаас анх удаа батлан гаргаж мөрдөн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, төрийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр нийт 4 тулгуур, 6 зорилт бүхий 20 заалт тусгаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн 35% буюу 8.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна.

Уг төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудад мөрдөж байгаа дүрэм журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, байгууллагууд нээлттэй утас ажиллуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг боллоо. Ёс зүйтэй манлайллыг аймгийн төрийн байгууллагын удирдлагууд өөрсдөөсөө эхэлж, шударга ёс хуулийг дээдлэн ажиллах, гаргаж буй шийдвэр, явуулж байгаа үйл ажиллагаагаа олон түмэнд ил тод нээлттэй байлгах, нийтийн эрх ашгийн хүрээнд гаргаж буй шийдвэрийг боловсруулахдаа иргэд, олон нийтийг оролцуулж саналыг нь авч байх уриалга гарган ажиллаж байна. Ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд 1475 иргэнээс санал асуулга авч, шударга ёс ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан иргэдийн төлөөлөл, ИНБ-ын сүлжээтэй хамтран 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллагууд “Шударга, ил тод төрийн байгууллага” нэртэй ижил загвар, хэмжээтэй самбартай болж, түүнд тухайн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, зарцуулсан төсөв хөрөнгө, зарлагдсан ажлын байр, тендерийн талаарх мэдээлэл г.м чухал шаардлагатай мэдээллүүдийг тогтмол тавьж хэвшүүлсэн нь төрийн байшууллагууд иргэдэд ил тод, нээлттэй ажиллах чиглэлд зохих ахиц, дэвшил гарсан гэж дүгнэж байна.

Ил тод байдлын үнэлгээний нийт дундаж оноо 95,3 хувь буюу 4,76 байна. /Khentii2010Re11.doc/

## **5. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ**

### **5.1 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн талаар**

2010 онд аймгийн ДНБ 54834,6 сая төгрөг болж, өмнөх оноос 0,2 хувиар буюу 92,7 сая төгрөгөөр өсч, нэг хүнд ноогдох ДНБ /2000 оны зэрэгцүүлэх үнээр/ 781,3 мянган төгрөг болж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг сүүлийн 3-н жил дараалан давуулан биелүүлж, энэ хэмжээгээр орон нутгийн бүтээн байгуулалтанд зарцуулагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. Мөн орон нутгийн төсөвт 5567,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орон нутгийн зарлагаас давсан 358,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2009, 2010 оны гүйцэтгэлээр **орлогын өсөлт зарлагын өсөлтөөс түрүүлж**, төсвийн урсгал болон нийт тэнцэл сайжирсан байна.

Хэнтий аймагт 2008 онд 5700,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдэж байсан бол 2009 онд 17100,0 сая төгрөгийн, 2010 онд 32821,9 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, хөрөнгө оруулалт жилээс жилд нэмэгдэж байна. Дээрх хөрөнгө оруулалтуудаас 2010 онд орон нутгийн төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын дүн 1186,2 сая төгрөг болж, өмнөх оноос 835,0 сая төгрөгөөр буюу 3,4 дахин өссөн байна.

Орон нутгийн урсгал төсөв сүүлийн 2 жил дараалан өргүй гарч, урсгал төсвийн авлага 13,2-21 хувиар бууран, 2010 оны жилийн эцсийн мэдээгээр орон нутгийн төсөв 10,9 сая төгрөгийн авлагатай байгаа нь өмнөх оноос 21,0 хувиар буурсан дүнтэй байна.

Нийгмийн үзүүлэлтийн хувьд боловсролын салбарт хамран сургалт, багш нарын хангалтын хувь ахисан, нэг компьютерт ногдох хүүхдийн тоо буурсан байна. Мөн ажилгүйдэл ядуурлын түвшин өнгөрсөн онтой харьцуулахад 0,1-2,6 хувиар, шилжилт хөдөлгөөний цэвэр коэффициент 1,2 хувиар тус тус буурсан, эхийн эндэгдэл гараагүй, урлагийн байгууллагуудад шинээр тавьсан бүтээлийн тоо 19,3 хувиар ахисан, нялхсын эндэгдлийн түвшин буурсан зэрэг сайн үзүүлэлтүүд байгаа боловч 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өнгөрсөн онтой харьцуулахад 8-аар нэмэгдэж, халдварт өвчний гаралт нилээд нэмэгдсэн нь сөрөг үзүүлэлт болж байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна.

2010 онд ЖДҮ-ийн тоо 12-оор нэмэгдэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ эрс өссөн байна. Өндөрхаан хотын дэргэд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж, хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэр ашиглалтанд оруулсан нь үр дүнтэй ажил болсон байна. Мөн энэ онд ашиглалтанд оруулсан хатуу хучилттай зам, шинээр ашиглалтанд оруулсан орон сууц, цэвэр бохир усны төвлөрсөн хангамжид хамрагдсан айл өрхийн тоо өмнөх жилүүдээс нэмэгдсэн нь иргэдийн ая тухтай амьдрах орчин сайжирч байгаагийн илрэл гэж үзэхээр байна.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн нийт дундаж оноо 4,4 байна. /Khentii2010Re12.doc/

### **5.2 Хэрэглэгчийн үнэлгээ**

Монгол улсын Засгийн газрын 11-р тогтоолоор батлагдсан “Аймаг нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу

Хэнтий аймгийн бүх сум, хот тосгоны ЗДТГ, ЗАА-наас ажлын хэсэг томилогдон үнэлгээний хуудсаар иргэдээс санал асуулга авч дүнг ирүүлснийг нэгтгэн боловсруулав. Уг санал асуулгад Хэнтий аймгийн хэмжээнд нийт 2270 иргэн хамрагдсан нь насанд хүрсэн нийт хүн амын 5,6%-ийг эзэлж байна. Санал асуулгыг явуулахдаа хүн амын нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харгалзан нийгмийн бүлэг бүрийн төлөөллийг жигд хамруулахыг зорьж сум бүрт хүн амын 5-аас доошгүй хувийг санал асуулгад хамруулсан байна. /Khentii2010Re13.doc/

Санал асуулгын бүрэн хангалттай, хангалттай, гэсэн үзүүлэлтүүдийг эерэг үнэлгээнд авч хангалтгүй гэсэн үнэлгээг сөрөг хандлагатай гэж тооцсон бөгөөд төдийлөн хангалттай биш, мэдэхгүй гэсэн үзүүлэлтүүдийг хасч тооцсон болно. Энэхүү санал асуулгад оролцсон 2270 иргэний 39,7% нь төрийн ажил үйлчилгээнд эерэг үнэлгээ, 19,3% хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна. Үлдсэн 41 хувь нь төдийлөн хангалттай биш, мэдэхгүй гэсэн дундаж хариултыг өгсөн байна. Ерөнхийдөө санал асуулгад оролцсон нийт иргэдийн 41 хувь нь санал асуулгын дүнд дундаж хариулт өгсөн нь иргэдийн нийгмийн идэвх сул байгааг харуулж байна.

Харин 2270 иргэний 44,6 хувь нь төрийн үйлчилгээг бүрэн хангалттай буюу хангалттай гэж үнэлсэн нь аймгийн төвд “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, 52 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх замаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн, иргэдэд ил тод, нээлттэй ажиллах, шударга төрийн байгууллага байх зарчмаар зохион байгуулж байгаа олон талт ажлууд үр дүнд хүрч байгааг харуулж байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ